



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГА Б.БААТАРЦОГТ
ТАНАА

2017.02.20 № 3/254
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Ашигт малтмал, газрын тосны газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА



Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ҮАГ-ын Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Утас: 261740
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Шинжээч : Д.Цэгмиддорж
Утас: 261740
tsegmiddorjd@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

ХУУДАС

- Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Менежментийн захидал
Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан
Хавсралт 5: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

АГУУЛГА

1.	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2.	Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4.	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5.	Дотоод хяналт.....	4
6.	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	5
7.	Шилэн дансны мэдээлэл.....	5
8.	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	5
9.	Гол, онцлог гүйлгээний талаар.....	6
10.	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	6
11.	Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	8
12.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
13.	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	8
14.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	8
15.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
16.	Зөвлөмж	9
17.	Аудитын гэрчилгээний тохирох загварын дүгнэлт.....	9

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /САГ-2017/365/13-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Ахлах аудитор Ж.Батсайхан, Аудитор Ш.Отгонбаяр, Шинжээч Д.Цэгмиддорж нар хэрэгжүүлж ажиллав.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Ашигт малтмалын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор хуучнаар Ашигт малтмалын газар, Газрын тосны газрыг нэгтгэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ашигт малтмал, газрын тосны газрыг шинэчлэн байгуулсан.

Тус газар нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаанд төрөөс баримтлан явуулж байгаа бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд дотоод зохион байгуулалтын 11 хэлтэс/1 лаборатори/-т 185 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын эрхэм зорилго:

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 1,759.1 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Unicus” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Дотоод хяналтын талаар

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг нь Ашигт малтмал, газрын тосны

газрын үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх болон статистик мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сургалт сурталчилгаа явуулах үндсэн үүргийг хүлээж, Ашигт малтмал, газрын тосны газрын ажилтнуудын цаг ашиглалтыг сайжруулах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, дотоод хяналт шалгалтын тогтолцоог буй болгох, удирдлагын шийдвэр, бодлого журмын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аппаратын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, салбарын холбогдолтой мэдээ, мэдээлэл, статистик тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулах, удирдах дээд байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, салбарын үйл ажиллагааг сурталчилан таниулах, сургалт, давтан сургалтын ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагаа нь Ашигт малтмал, газрын тосны газрын даргад болон газрын аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, ажилтнуудын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх замаар хэрэгждэг байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Газрын тосны орлогоор 54,561.0 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 65,383.8 сая төгрөгийг төвлөрүүлж 19.8 хувиар давуулан биелүүлсэн, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, улсын төсвөөр хийсэн хайгуулын нөхөн төлбөрийн орлого, бусад орлого батлагдсан төсвөөр 15,781.9 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 19,454.1 сая төгрөгийг төвлөрүүлж 23.3 хувь буюу 14,495.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Батлагдсан зардлын төсөв /төсвийн тодотголоор/ 1,797.8 сая төгрөгөөр батлагдснаас гүйцэтгэлээр 1,651.1 сая төгрөгийг зарцуулсан буюу төсвийн гүйцэтгэл 91.8 хувьтай байна.

Долоо. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажиллаж байна. Тайлант онд Ашигт малтмал, газрын тосны газрын хувьд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 568 гүйлгээгээр 94,304.0 сая төгрөг, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 121 гүйлгээгээр 53,629.8 сая төгрөгийн мэдээллийг байршуулсан байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаар

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, бусад орлого, цалин, ЭМД, НДШ, ХХОАТ, халаалт, цахилгаан, шатахууны зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журмын 3 дугаар зүйлийн 3.1.10, Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын “Нийгмийн асуудлыг шийдвэрлэх тухай” 2016 оны 12 дугаар сарын 20-ны б/169 дугаар тушаалаар нийт албан хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 169 албан хаагчдад 111.0 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төлөөлөгчийг дэмжих сангаас ГТГ-ын даргын 2016 оны 86 дугаар тушаалаар нийт 11 хүнийг нийт 33.0 сая төгрөгөөр шагнаж, урамшуулсан ба зөрчлийг дахин давтан гаргасан, урьд оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. /Албан шаардлага өгөх/
2. Төлөөлөгчийг дэмжих сангийн харилцахын нийт 978.3 сая төгрөгийн 91 ажил гүйлгээнээс, **4.9** сая төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. Дээрх зардал нь Монгол-Германы Засгийн газрын хоорондын ажлын хэсгийн 5 дугаар хуралдаанд оролцох Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төлөөлөгчийн замын зардал байна. /Албан шаардлага өгөх/

Шийдвэрлэсэн нь: Газрын тосны газрын даргын 2011 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төлөөлөгчийг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т заасныг мөрдөж ажиллах тухай акт, албан шаардлага өгөх

1. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 11,816.3 сая төгрөгийн авлагатай байна. Үүнээс Голден сий петролеум ХХК-тай холбоотой **275.7** сая төгрөгийн авлагад тооцоо нийлсэн актгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион

байгуулах, удирдах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллах шаардлагатай тухай зөвлөмж өгөх,

1. Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгэлтэй 3 нэр төрлийн 55 ширхэг, **12.0** сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ашиглагдаж байна.
2. Төрийн өмчийн хорооны 2015 оны 780 дугаар тогтоолоор 147.6 сая төгрөгийн балансын үнэтэй 49.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий үндсэн хөрөнгийг актлахаар шийдвэрлэсний дагуу нийт **126.0** сая төгрөгийн балансын үнэтэй 5 ширхэг контейнерыг балансаас хасахдаа, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолын 5.5 "а"-д заасан эд хөрөнгийг худалдах болон 5.5 "г"-д шууд устгах, гэж зааснаар устгасан, худалдсан тухай акт, баримт материал байхгүй байна. /албан шаардлага өгөх/
3. Тус байгууллагын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтгүй олон жил болсон цаашид ашиглах боломжгүй **48.5** сая төгрөгийн тавилга эд хогшил, **129.5** сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна
4. Ашигт малтмал, газрын тосны газар нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.
5. Тус байгууллагын даргын “Эд хөрөнгийн тооллого хийх тухай” 2016 оны 76 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс 1 ш контейнер Хэт ХХК-д 2009 онд алдагдсан 2 ш хөлдөөгч, 1 ш хөргөгчийг байгаагаар тоологдсон зэрэг зөрчил дутагдалыг илрүүлж өмч хамгаалах байнгийн зөвлөлд танилцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.4, 30 дугаар зүйлийн 30.3-т, “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар бүлгийн 5.2.4, 5.4, 5.5 “а”, “г, заасныг дагаж мөрдөх тухай зөвлөмж өгөх,

- Эрлийн ажил гүйцэтгэх 13 гэрээний 3.4.10-т заасан “Газрын тосны газарт буцалтгүйгээр автомашин авч өгөх” заалтыг биелүүлээгүй нэр бүхий 9 компани, мөн Жени Монголиа Холдинг ХХК нь байгуулсан гэрээнийхээ дагуу машин өгсөн боловч, тус байгууллага нь буцаан авсан байгаа нь эрлийн ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт сул байна.
- Таван богд ХХК-тай байгуулсан 74.0 сая төгрөгийн үнэтэй Toyota HiAce загварын авто машин худалдан авах гэрээний 2.2-т заасны дагуу урьдчилгаа төлбөр болох 18.5 сая төгрөгийг шилжүүлээд, гэрээний тусгай нөхцлийн 14.4.2-т заасны дагуу Газрын тосны газар нь /хуучин нэрээр/ авто машиныг хүлээн авах ёстой боловч, автомашиныг хүлээн авсан баримт материал байхгүй байна. Дээрх авто машиныг ямар нэгэн тогтоол шийдвэргүйгээр Засгийн газрын авто баазад хүлээлгэн өгсөн акттай байна. /албан шаардлага өгөх/

Шийдвэрлэсэн нь: Цаашид гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах, тухайн гэрээнүүдэд заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах, Төрийн болон

орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т заасныг мөрдөж ажиллах,

- 2016-2017 оны хичээлийн жилд шинээр сургалтын тэтгэлэгт хамрагдсан суралцагсадаас магистрын нийт 5 суралцагч уул уурхайн болон газрын тосны мэргэжлээр бакалаврын зэрэггүй, бөгөөд уул уурхай, газрын тосны чиглэлээс өөр мэргэжлээр суралцаж байна. Нэр бүхий 2 суралцагч 2015 онд Их дээд сургууль төгссөн байгаа нь “Журам батлах тухай” ЗГ-ын 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан журмын 2.2.3-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: “Журам батлах тухай” ЗГ-ын 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан журмын 2.2.3-т магистрын сургалтад хамрагдах иргэн нь газрын тос, уул уурхайн салбарын чиглэлийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш жил их, дээд сургуульд багшилсан эсхүл ажилласан байх гэсэн заалтыг мөрдөж ажиллах, /албан шаардлага өгөх/

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 703.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 3 зөвлөмж, 5 албан шаардлага өгсөн болно.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 оны завсрын аудитаар санхүүгийн тайланд ҮАГ-аас 6 зөвлөмж өгсөн байна. Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд хэрэгжүүлээгүй зөвлөмжийг албан шаардлага болгосон болно.

Арван зургаа. Зөвлөмж

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж, 5 албан шаардлага өгч байна.

/Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн -талаар/ Агуулга 10-т дэлгэрэнгүй байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан / . . . хуудас/-ыг хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

БЭЛТГЭСЭН:

ШИНЖЭЭЧ

Д.ЦЭГМИДДОРЖ

АУДИТОР

Ш.ОТГОНБАЯР

АХЛАХ АУДИТОР

Ж.БАТСАЙХАН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2017 оны 2 дугаар сар



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1, 2, 3 зүйлс:

Асуудал 1

Авлага өглөгийн талаархуудас 3

Асуудал 2

Үндсэн хөрөнгийн талаархуудас 4

Асуудал 3

Гэрээ ажил үйлчилгээний талаархуудас 5

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг **Ашигт малтмал, газрын тосны газрын** удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь **Ашигт малтмал, газрын тосны газрын** хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээрх зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээрх зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан **Ашигт малтмал, газрын тосны газрын** санхүүгийн болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

Асуудал 1 Авлага өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол № 1

ҮАГ-ын ажиглалт

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 11,816.3 сая төгрөгийн авлагатай байна. Үүнээс Голден сий петролеум ХХК-тай холбоотой **275.7** сая төгрөгийн авлагад тооцоо нийлсэн актгүй байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 9 дүгээр сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

- Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгэлтэй 3 нэр төрлийн 55 ширхэг, **12.0** сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ашиглагдаж байна.
- Тус байгууллагын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтгүй олон жил болсон цаашид ашиглах боломжгүй **48.5** сая төгрөгийн тавилга эд хогшил, **129.5** сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна
- Ашигт малтмал, газрын тосны газар нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.
- Тус байгууллагын даргын “Эд хөрөнгийн тооллого хийх тухай” 2016 оны 76 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс 1 ш контейнер Хэт ХХК-д 2009 онд алдагдсан 2 ш хөлдөөгч, 1 ш хөргөгчийг байгаагаар тоологдсон зэрэг зөрчил дутагдалыг илрүүлж өмч хамгаалах байнгийн зөвлөлд танилцуулсан байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, ашиглал шамшигдал үүсэх,

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т төрийн байгууллага, албан газар нь “Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах”, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “3. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”

Ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглалтгүй олон жил болсон багаж, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж холбогдох арга хэмжээ авч ажиллах.

Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 9 дүгээр сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний 3.4.10-т заасны дагуу Газрын тосны газарт буцалтгүйгээр автомашин авч өгөх гэж заасныг биелүүлээгүй нэр бүхий 9 байгууллагын 13 гэрээ, Жени Монголиа Холдинг ХХК-тай байгуулсан гэрээний дагуу машин өгсөн боловч, тус байгууллага нь буцаан авсан байна. Тухай байгууллагуудтай байгуулсан эрлийн ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт сул байна. Эрлийн гэрээний 3.4.10-т болон бусад заалтуудыг мөрдүүлж ажиллах шаардлагатай байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Цаашид гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 9 дүгээр сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө дутагдах, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,389,740,941.02	35,990,861,839.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	99,095,511.14	430,415,362.30
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	90.40	1,113,716.14
31110	Төгрөг	90.40	-
31120	Гадаад валют	-	1,113,716.14
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	97,918,734.86	426,417,674.69
3121	Төгрөг	97,547,444.44	26,635,205.08
31211	Төрийн сангийн харилцах	26,635,205.08	26,635,205.08
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	70,912,239.36	
3122	Гадаад валют	371,290.42	399,782,469.61
31223	Арилжааны банк дахь харилцах	371,290.42	399,782,469.61
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	1,176,685.88	2,883,971.47
33	АВЛАГА	7,529,191,544.60	11,816,349,733.96
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,207,655.83	318,033.29
335	Бусад авлага	7,526,983,888.77	11,816,031,700.67
3351	Байгууллагаас авах авлага	7,523,597,109.41	11,815,031,700.67
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,386,779.36	1,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	99,529,176.25	28,358,076.25
34600	Урьдчилж гарсан зардал	94,138,076.25	28,358,076.25
3471	Урьдчилгаа тооцоо	5,391,100.00	0.00
34714	Томилолтын урьдчилгаа	5,391,100.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	486,534,355.75	540,348,313.81
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	3,408,740.00	3,408,740.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	620,604.92	620,604.92
354	Хангамжийн материал	482,505,010.83	536,318,968.89
35410	Бичиг хэргийн материал	22,313,017.23	29,985,058.40
35420	Аж ахуйн материал	446,251,805.83	471,087,179.19
35430	Сэлбэг хэрэгсэл	2,899,797.62	22,572,239.91
35440	Түлш, шатах тослох материал	11,040,390.15	12,674,491.39
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390,353.28	23,175,390,353.28
36400	Шатахууны нөөц	23,175,390,353.28	23,175,390,353.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,255,526,871.42	9,147,493,919.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,255,526,871.42	9,147,493,919.27
392	Биет хөрөнгө	9,025,693,864.52	8,784,498,882.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,524,134,652.31	6,531,327,450.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,442,656,138.09)	(1,499,615,786.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,945,283,992.73	2,157,534,117.94
39204	Хуримтлагдсан элэгдэл	(913,530,776.16)	(896,236,426.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,930,697,836.84	5,969,054,436.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,604,092,684.27)	(4,021,154,743.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,050,373,389.33	1,054,872,389.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(804,503,586.41)	(827,874,613.72)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	527,413,320.00	527,413,320.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(317,552,011.90)	(340,238,783.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,991,100.00	46,991,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,031,989.86)	(7,740,339.86)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	90,166,760.00	90,166,760.00
393	Биет бус хөрөнгө	229,833,006.90	362,995,036.78
39301	Програм хангамж	1,008,241,651.70	1,172,895,431.70

39302	Хуримтлагдсан элэгдэл	(778,408,644.80)	(809,900,394.92)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>40,645,267,812.44</u>	<u>45,138,355,758.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>233,889,535.10</u>	<u>30,488,293.61</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	233,889,535.10	30,488,293.61
413	Өглөг	207,254,330.02	3,853,088.53
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,674,831.20	
4136	Бусад өглөг	202,579,498.82	3,853,088.53
41361	Байгууллагад төлөх өглөг	161,937,673.60	3,533,166.06
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	13,947,136.00	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	9,789,749.41	319,922.47
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	16,904,939.81	-
414	Урьдчилж орсон орлого	26,635,205.08	26,635,205.08
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	26,635,205.08	26,635,205.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>40,411,378,277.34</u>	<u>45,107,867,465.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	40,411,378,277.34	45,107,867,465.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		9,979,642,904.22	9,979,642,904.22
51101	Өмч: - төрийн	9,979,642,904.22	9,979,642,904.22
512	Хуримтлагдсан үр дүн	29,772,185,186.80	34,468,674,374.72
51210	Өмнөх үеийн үр дүн	29,772,185,186.80	29,772,185,186.80
51220	Тайлант үеийн үр дүн		4,696,489,187.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	659,550,186.32	659,550,186.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>40,645,267,812.44</u>	<u>45,138,355,758.87</u>

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтг.	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	92,443,192,086.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	17,924,038,241.75
118	Бусад татвар, төлбөр, хураамж	-	17,924,038,241.75
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	-	17,924,038,241.75
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	-	17,174,070,844.97
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр		749,967,396.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	72,868,025,039.68
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	72,868,025,039.68
120002	Хүүгийн орлого		17,052,763.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	7,625,632,201.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,511,058,777.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,114,573,424.00
120006	Газрын тосны орлого		65,169,323,851.04
120009	Бусад орлого		56,016,223.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,651,128,805.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,651,128,805.56
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,651,128,805.56
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	87,953,096,130.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	87,953,096,130.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2,487,091,714.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	1,074,845,603.51
210101	Үндсэн цалин		605,582,464.12
210102	Нэмэгдэл		366,859,432.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт		93,626,600.00
210105	Гэрээт ажлын хөлс		8,777,107.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	118,960,704.66
210201	Тэтгэврийн даатгал		76,922,236.03
210202	Тэтгэмжийн даатгал		8,579,898.63
210203	ҮОМШӨ-ний даатгал		10,504,073.52
210204	Ажилгүйдлийн даатгал		2,086,772.44
210205	Эрүүл мэндийн даатгал		20,867,724.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	70,227,881.44
210301	Гэрэл, цахилгаан		8,464,943.00
210302	Түлш, халаалт		42,960,676.44
210303	Цэвэр, бохир ус		6,033,509.00
210304	Байрны түрээс		12,768,753.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	78,305,025.31
210401	Бичиг хэрэг		25,335,873.40
210402	Тээвэр, шатахуун		21,403,407.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		17,924,417.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		13,521,327.35
2105	Нормативт зардал	0.00	4,620,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		4,620,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	16,326,835.95
210601	Багаж, техник, хэрэгсэл		34,198.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		869,440.00
210604	Урсгал засвар		15,423,197.95
2107	Томилолт, зочны зардал	0.00	58,813,773.29
210701	Гадаад албан томилолт		15,912,895.20
210702	Дотоод албан томилолт		29,702,483.60
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		13,198,394.49

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	367,357,935.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		269,680,783.04
210803	хураамж		16,903,920.00
210806	Даатгалын үйлчилгээ		79,609,500.00
210807	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,163,732.00
2109	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	697,633,955.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,270,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		691,363,955.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	552,271,432.18
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		126,128,544.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		338,806,253.84
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		56,987,301.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		30,349,333.34
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	68,880,618,442.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		68,880,618,442.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	75,043,492.53
213404	Хөрөнгийн		75,043,492.53
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	15,958,071,048.86
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		15,958,071,048.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	4,490,095,956.11
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	533,410,126.71
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		426,192,318.67
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		107,217,808.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	327,016,894.90
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		203,005,184.83
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		124,011,710.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	206,393,231.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	4,696,489,187.92

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	88,248,005,140.43
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	17,924,038,241.75
118	Бусад татвар, төлбөр, хураамж	0.00	17,924,038,241.75
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	0.00	17,924,038,241.75
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр		17,174,070,844.97
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр		749,967,396.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	68,431,385,700.68
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	68,431,385,700.68
120002	Хүүгийн орлого		17,052,763.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3,244,767,085.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,582,567,295.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,662,199,789.91
120006	Газрын тосны орлого		65,169,323,851.04
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/		242,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,892,581,198.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,743,319,603.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,743,319,603.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	93,470,400.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		93,470,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	55,791,195.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		55,791,195.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	87,689,757,541.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	87,689,757,541.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2,043,562,890.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	1,096,255,896.32
210101	Үндсэн цалин		771,646,521.72
210102	Нэмэгдэл		172,787,800.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт		73,716,750.09
210104	Урамшуулал		34,265,400.00
210105	Гэрээт ажлын хөлс		43,839,424.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	124,947,267.02
210201	Тэтгэврийн даатгал		124,947,267.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	75,430,481.09
210301	Гэрэл, цахилгаан		10,977,243.00
210302	Түлш, халаалт		45,650,976.09
210303	Цэвэр, бохир ус		6,033,509.00
210304	Байрны түрээс		12,768,753.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	137,951,942.17
210401	Бичиг хэрэг		30,965,368.28
210402	Тээвэр, шатахуун		61,982,438.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		24,384,966.43

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		20,439,169.00
2105	Нормативт зардал	0.00	4,056,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		4,056,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	43,051,290.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,606,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		869,440.00
210604	Урсгал засвар		32,575,400.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	92,935,691.60
210701	Гадаад албан томилолт		33,353,855.20
210702	Дотоод албан томилолт		50,352,743.60
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		9,229,092.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	385,428,158.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		278,810,250.28
210803	Даатгалын үйлчилгээ		16,903,920.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		87,527,256.00
210807	Газрын төлбөр		1,163,732.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1,023,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	83,506,164.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		75,416,464.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,089,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	85,646,194,651.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	581,019,650.65
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		133,410,889.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		356,279,544.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		69,478,927.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,850,290.65
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	78,503,516.69
213404	Хөрөнгийн		78,503,516.69
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	84,986,671,484.05
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		84,930,880,289.05
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		55,791,195.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	558,247,598.56
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	529,037,356.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	529,037,356.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	529,037,356.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		529,037,356.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	(529,037,356.00)
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	0.00	(302,109,608.60)
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		(302,109,608.60)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	302,109,608.60
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	331,319,851.16
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	99,095,511.14	99,095,511.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,095,511.14	430,415,362.30

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Буса д	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 08-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	29,772,185,186.80		40,411,378,277.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	29,772,185,186.80	0.00	40,411,378,277.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 08-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	29,772,185,186.80	0.00	40,411,378,277.34
D01	2016 оны 08-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	29,772,185,186.80	0.00	40,411,378,277.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	29,772,185,186.80	0.00	40,411,378,277.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			4,696,489,187.92		4,696,489,187.92
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	34,468,674,374.72	0.00	45,107,867,465.26

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА	-	-	2,994,061,600.00	2,007,408,349.56
21	УРСГАЛ ЗАРЛАГА	-	-	2,994,061,600.00	2,007,408,349.56
210	БАРАА, АЖИЛ ОЛГОГЧООС ОЛГОХ	-	-	1,514,606,400.00	1,443,264,443.56
2101	Цалин хөлс	-	-	962,343,000.00	960,298,722.53
210101	Үндсэтгэл	-	-	658,060,800.00	657,546,960.92
210102	Нэмэгдэл			173,093,900.00	172,787,800.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт			73,716,900.00	73,716,750.09
210104	Урамшуулал			34,265,400.00	34,265,400.00
210105	Гэрээт ажлын хөлс			23,206,000.00	21,981,811.33
2102	Ажил олгогчоос олгох	-	-	105,858,100.00	105,730,013.15
210201	Тэтгэврийн даатгал			105,858,100.00	105,730,013.15
2103	Байр ашиг	-	-	68,741,700.00	60,846,618.85
210301	Гэрэл, цахилгаан			12,561,500.00	10,933,838.00
210302	Түлш, халаалт			43,143,000.00	43,265,071.85
210303	Цэвэр, бохир ус			10,787,200.00	5,767,709.00
210304	Байрны түрээс			2,250,000.00	880,000.00
2104	Хангамж	-	-	75,643,900.00	71,909,245.43
210401	Бичиг хэрэг			26,361,400.00	26,176,679.00
210402	Тээвэр, шатахуун			7,229,600.00	7,229,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			24,318,300.00	21,132,951.43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөлдөөн			400,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн хэрэгсэл			17,334,600.00	17,190,015.00
2105	Норматив	-	-	636,200.00	416,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			636,200.00	416,000.00
2106	Эд хогшил	-	-	18,836,800.00	3,872,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл			3,018,400.00	2,534,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			1,090,800.00	869,440.00
210604	Урсгал засвар			14,727,600.00	469,500.00
2107	Томилол	-	-	72,168,800.00	37,852,743.60
210702	Дотоод албан томилолт			72,168,800.00	37,852,743.60
2108	Бусдаар	-	-	200,477,900.00	198,638,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийгэмлэг			196,604,600.00	196,477,828.00
210807	Газрын төлбөр			2,509,500.00	1,137,332.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх			1,363,800.00	1,023,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	9,900,000.00	3,700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			3,500,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага			6,400,000.00	3,700,000.00
213	УРСГАЛ ШИНЖЛЭЛИЙН	-	-	1,479,455,200.00	564,143,906.00
2132	Бусад урсгал	-	-	1,479,455,200.00	564,143,906.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэвэр			211,238,700.00	138,385,435.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урсгал			1,196,237,500.00	356,279,544.00

213206	Ээлжийн амралтаар нутаг явах ү	2,500,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаа	69,479,000.00	69,478,927.00